



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд
санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний
хэрэгжилт, үр дүн, үр ашиг**

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
хэрэгжиж байгаа сургуулийн барилгын
ажлын явц удаашралтай байна**



2017 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган Аудитын менежер Х.Женисбек Ахлах шинжээч К.Риза Шинжээч Ж.Назгүл 2017 оны 04 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930, 70422954 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр 1,2 дугаар давхар 102, 104, 108 тоот өрөө	Товчилсон үгийн тайлбар	4	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6	4
	Бүлэг 1.		
	2016 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр болон бодит хэрэгцээнд үндэслэн хийгджээ	7-10	
	1.1. ТАХ-г нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн эсэх талаар.	7	
	1.2. Хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, үр ашиггүй хөрөнгө оруулалтын ТАХ төлөвлөсөн эсэх талаар.	8	
	1.3. Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдоогүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх талаар.	8	
	1.4. ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөл иж бүрэн, хуулийн шаардлага хангасан эсэх талаар.	9	
	1.5. ТАХ-ний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн, санхүүжих дүнд өөрчлөлт орж хуульд тусгасан эсэх талаар.	9	
	1.6. Төсвийн тухай хуульд ТАХ-ний нэр, эхлэх дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан эсэх талаар.	9-10	
	1.7. ТАХ-г төлөвлөхдөө шилжих арга хэмжээнд шаардлагатай санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилж, шат шатны хяналтыг тавьж батлуулсан эсэх талаар.	10	
	Бүлэг 2.		
	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хуулийн дагуу хугацаандаа үр нөлөөтэй зохион байгуулагджээ.	11-13	
	2.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, ил тод, шуурхай байдлыг хангасан эсэх талаар.	11	
	2.2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны журмыг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан эсэх талаар.	11-12	
	2.3. Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж тайлагнасан эсэх талаар.	12	
	2.4. Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, үр ашиггүй зарцуулсан эсэх талаар.	13	
	2.5. Худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдах, бэлтгэл ажил хангагдсан ТАХ-д гүйцэтгэгч сонгон шалгаруулсан эсэх талаар.	13	

2.6. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТАХ-ний зориулалтыг өөрчилсөн эсэх талаар. 13

Бүлэг 3.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна

3.1. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлүүд тодорхойгүй, оновчтой бус хугацаа хэтэрсэн эсэх талаар 14

3.2. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, бүрэн ашигласан эсэх талаар. 14-16

3.3. ТАХ-ний ажлын гүйцэтгэл дутуу болон хуурамч гүйцэтгэлд санхүүжилт олгосон, талуудын хяналт хангалтгүйгээс зураг төсөвт өөрчлөлт орсон, үргүй зардал гаргасан эсэх талаар. 16

3.4. ТАХ-ний санхүүжих дүн дутуу батлагдсанаас, бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүйгээс арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшилсон эсэх талаар. 17

3.5. ТАХ-ний хэрэгжилтэд тавих талуудын хяналт хангалтгүй байх, захиалагч гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулсан эсэх талаар. 17-18

3.6. Хэрэгжиж дууссан ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан эсэх талаар 18

3.7. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний үр ашиг хангалттай, чанарын болон ашиглалтын шаардлага хангасан эсэх талаар 18-26

Урьд өгсөн оны зөвлөмжийн хэрэгжилтийн талаар 26-27

Дүгнэлт 28

Зөвлөмж:..... 29

Холбогдох байгууллагын санал:

Саналд өгсөн тайлбар 30

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ХААУХШМС	Худалдан авах ажиллагааны удирдлагын хяналт, шалгалтын мэдээллийн систем
БЗА	Барилга захиалагчийн алба
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхий аудиторгоос баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад УИХурал, яамдууд, аймаг, сумдын ИТХурал, Засаг дарга, ЗДТГазраас гаргасан холбогдох шийдвэрүүд, Худалдан авах ажиллагааны нэгжээс зохион байгуулсан ажлын үр дүн, ажлын явцын болон холбогдох санхүүгийн ажлын тайлан, бусад тооцоо судалгаа үйл ажиллагаануудыг хамрууллаа.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, харилцан ярилцлагад тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ. /Хавсралт №1/

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журам, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны албаны удирдах болон холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, санал, асуулга, лавлагаа авах, фото, судалгаа авч дүн, шинжилгээ хийх, зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Асуудлын талаар товч мэдээлэл:

Тус аймагт Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр 9,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээг 1,1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд 990,9 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- УИХ, Засгийн газрын тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах шинжээч К.Риза, шинжээч Ж.Назгүл нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хуваарийн дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд гүйцэтгэлийн аудит хийж аудитын тайланг бэлтгэв. Аудитын тайлангийн хавсралт судалгаа мэдээнүүдийг тайланд хавсаргасан болно.

Бүлэг 1

2016 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр болон бодит хэрэгцээнд үндэслэн хийгджээ.

Оршил

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнд батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 19-ныг хүртлэх хугацаанд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Гүйцэтгэлийн аудитад 2016 онд Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, орон нутагт эрх шилсэн төсөл, арга хэмжээ болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг бүрэн хамруулав.

Улсын төсвийн хөрөнгөөр Баян-Өлгий аймагт 2016 онд шинээр хэрэгжих 5, он дамжин хэрэгжиж байгаа 2 буюу нийтдээ 9709,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 1158,8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр 2016 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, орон нутагт зохион байгуулан хэрэгжүүлэхээр эрх шилжүүлжээ.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 68 дугаар тогтоолоор 2016 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг 2015 оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 990,9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Мөн Аймгийн ИТХ-ын 2016 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар дээрхи төсвийг 7,1 сая төгрөгөөр нэмж тодотгон 71 дүгээр тогтоол гаргажээ. Уг тогтоолоор 2016 онд хэрэгжүүлэх 26 төсөл арга хэмжээнд 830,2 сая төгрөгийг, ирэх онд хэрэгжих төсөл, арга хэмжээний зураг төсвийн зардал, тусламжийн хөрөнгийн тээврийн зардал, гадаадын тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээний орон нутгийн оролцоо зэрэг хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон зардлуудад 175,9 сая төгрөгийг нийтдээ 1006,1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын чиглэлээр зарцуулахаар баталсан байна.

1.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн талаар

2016 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр болон бодит хэрэгцээнд үндэслэн хийгджээ.

1.1. ТАХ-г нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн эсэх талаар.

Баян-Өлгий аймагт 2016 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын зорилт, Засгийн газрын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

төлөвлөгөө, Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтууд, төсвийн хүрээний мэдэгдэл, Монгол Улсын 2016 оны төсвийн төлөвлөгөө болон аймгийн Хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан, салбарын бодлоготой уялдсан байна.

1.2. Хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, үр ашиггүй хөрөнгө оруулалтын ТАХ төлөвлөсөн эсэх талаар.

2016 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж шинээр хэрэгжсэн 4 засварын ажлын зураг төсөв, аймгийн ЗДТГазрын тоног төхөөрөмжийн үнийн судалгаа зэрэг хөрөнгө оруулалтын хэмжээг тогтооход үндэслэл болгохоор зураг төсөв, тооцоо судалгааг захиалагч байгууллагаас урьдчилан бэлтгэж харьяа яаманд хүргүүлж, түүний дагуу яамнаас хөрөнгө хуваарилагдсан байна.

Орон нутгийн төсвийн байгууллага, иргэдээс аймгийн удирдлагуудад ирүүлсэн хүсэлт, бодит хэрэгцээ шаардлагыг харгалзан орон нутагт нэн тэргүүний хэрэгцээтэй тулгамдсан төсөл, арга хэмжээнүүдийг нэгтгэн аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтсээс шаардлагатай тооцоо судалгааны хамт аймгийн Засаг даргаар хянуулан батлуулж, улмаар уг жагсаалтыг аймгийн ИТХурлын хуралдаанд оруулан батлуулсан байна.

Тус аймагт 2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө 2013-2016 онуудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналын эрэмбэлсэн жагсаалт, салбарын удирдах байгууллагууд болон төсвийн байгууллагууд, иргэдийн санал, хөрөнгө оруулалт шаардлагатай объектийн бодит байдалд хийсэн МХГазрын улсын байцаагчийн дүгнэлт зэргийг харгалзан үзсэн байна.

2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн байгууллагуудаар нь авч үзвэл орон нутгийн төсвийн байгууллагуудад 924,8 сая төгрөгийн, улсын төсвийн 6 байгууллагад 75,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд төсөв батлан хэрэгжүүлсэн байна.

Үүнээс үзэхэд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчиж, Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги, Прокурор, Шүүхийн шинжилгээний алба, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн алба, Цагдаагийн газар зэрэг улсын төсвийн 6 байгууллагын хөрөнгө оруулалтын арга хэмжээнд орон нутгийн төсвөөс хөрөнгө төсөвлөн хэрэгжүүлсэн байна. Иймд дээрхи хууль зөрчиж баталсан 75,7 сая төгрөгийг зөрчилд тооцон дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгөв.

1.3. Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдоогүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх талаар.

Тус аймагт 2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Өлгий сумд баригдаж байгаа “Асрамжийн газрын байр барих” төсөл арга хэмжээний газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд нь 2014 онд хийгдэж бэлэн болсон ба бусад ажлууд нь ашиглагдаж байгаа хуучин барилга объектийг засварлах ажлууд байна.

1.4. ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөл иж бүрэн, хуулийн шаардлага хангасан эсэх талаар.

2016 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орсон төсөл, арга хэмжээнүүдийн зураг төсөв нь урьдчилан хийгдээгүй байна.

2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж шинээр хэрэгжсэн “Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн байрны засвар”, “Ногооннуур сумын БДС-ийн хичээлийн байрны хаалга, цонх шинэчлэх”, “Өлгий сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн өргөтгөл”, “Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засвар” зэрэг 4 ажлын, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр барьж байгаа “Асрамжийн газрын байр барих” ажил мөн 11 хуучин байр объектийг засварлах ажил зэрэг нийтдээ 16 төсөл арга хэмжээг мэргэшсэн төсөвчинөөр гаргуулсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 4 төсөл арга хэмжээ болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Асрамжийн газрын байр барих” зэрэг 5 төсөл, арга хэмжээний зураг төсвийг төсөв батлагдахаас өмнө гаргуулж, үлдсэн 296,0 сая төгрөгийн өртөг бүхий 11 төсөл арга хэмжээний зураг төсөв нь төсөв батлагдсаны дараа хийгдэж, төсвийн төсөл боловсруулах журмыг зөрчжээ.

Иймд Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1-хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3-д “Хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэснийг үндэслэн дээрхи зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөмж өгөгдөв.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Булган, Бугат, Цэнгэл сумдад автомашин нийлүүлэх”, “Нэгдсэн эмнэлэгт цахилгааны генератор тавих”, “Боловсрол соёлын газрын автомашины засварын ажил” зэрэг төсөл арга хэмжээнүүдэд захиалагчаас техникийн тодорхойлолт гаргуулсан байна.

Тайлант онд зураг төсвийн дагуу ажил гүйцэтгэх явцад зураг төсөвтэй холбоотой зөрчил маргаан гараагүй байна.

1.5. ТАХ-ний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн, санхүүжих дүнд өөрчлөлт орж хуульд тусгасан эсэх талаар.

2016 онд шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртөгт өөрчлөлт орсон, төсөл, арга хэмжээний төсөвт өртөг үндэслэлгүй нэмэгдсэн тохиолдол гараагүй байна.

Харин 2014 оноос орон нутгийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж байгаа “Төв талбайн шинэчлэл”-ийн ажлын зураг төсөвт экспертиз хийлгэсний дагуу материалын үнийн зөрүүд 170,0 сая төгрөг, захиалагчийн хүсэлтийн дагуу зураг төсөвт тусгагдаагүй авто машины зогсоол гаргах ажлын төсөвт 67,0 сая төгрөг нэмж дээрхи ажлын төсвийг нийтдээ 237,0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн санхүүжих дүнд өөрчлөлт оруулсан байна.

1.6. Төсвийн тухай хуульд ТАХ-ний нэр, эхлэх дуусах хугацаа, байршил болон ангилал зөрүүтэй тусгагдсан эсэх талаар.

БСШУСайдын 2016 оны төсвийн багцаар хэрэгжих хөрөнгө оруулалтын жагсаалтанд тус аймгийн “Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн байрны засвар”, “Өлгий сумын 2, 5 дугаар цэцэрлэгүүдийн дээврийн их засвар” зэрэг 150,0 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан боловч Өлгий сумын 2, 5 дугаар цэцэрлэгүүдийн дээврийн засварыг Японы “Өвсний үндэс” хөтөлбөрөөр хийхээр болсон тул аймгийн Засаг даргын 1-01/601 тоот албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийн дагуу дээрхи 2 ажилд батлагдсан 100,0 сая төгрөгийг Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны хаалга, цонх шинэчлэх, Өлгий сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн ажилд БСШУ-ны сайдын 2016 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/120 тоот тушаалаар шилжүүлсэн байна.

2016 оны Төсвийн тухай хуульд эрүүл мэндийн салбарын их засварын төсөл арга хэмжээний хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засварын ажилд 240,0 сая төгрөгийн төсөв батлагдсаны дагуу хэрэгжижээ.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 71 тоот тогтоолоор батлагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтаар баталсан хэрэгжих төсөл арга хэмжээний нэр, хугацаа, байршил өөрчлөгдөөгүй байна.

1.7. ТАХ-г төлөвлөхдөө шилжих арга хэмжээнд шаардлагатай санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилж, шат шатны хяналтыг тавьж батлуулсан эсэх талаар.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ болон ирэх жилүүдэд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсөвт зориулан жил бүр зохих хэмжээний хөрөнгө төлөвлөж, хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг дээшлүүлэхэд санхүүгийн нөөцөө хуваарилж ажилласан байна.

Тухайлбал: 2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд он дамжин хэрэгжиж байгаа Төв талбайн ажлын үргэлжлэлд 237,0 сая төгрөг, урьд жилд хэрэгжиж дууссан боловч тодорхой шалтгаанаар санхүүжилт нь дутуу олгогдсон Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн засварын ажлын санхүүжилтийн дутууд 40,0 сая төгрөг, шинээр баригдах 900 айлын хорооллын гадна инженерийн зураг төслийн ажилд 25,0 сая төгрөгийн төсвийг тус тус батлан хэрэгжүүлжээ.

Бүлэг 2

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хуулийн дагуу хугацаандаа үр нөлөөтэй зохион байгуулагджээ.

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулсан эсэх талаар

2.1. Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгож, ил тод, шуурхай байдлыг хангасан эсэх талаар.

Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны 2016 оны төлөвлөгөөний дагуу бараа ажил үйлчилгээний өртөг нь шууд худалдан авч болох босго үнээс давсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 5 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 10 төсөл арга хэмжээ бүгд 15 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ХАА-ны албаар дамжуулан зохион байгуулсан ба Татварын хэлтэст тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Татварын хэлтэсээс тус тус зохион байгуулан нийтдээ 16 бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг ажил тус бүр дээр байгуулсан үнэлгээний хороогоор сонгон шалгаруулжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь зүйлд заасан шаардлагыг хангахуйц худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, тухайн бараа, ажил үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн мөн иргэдийн төлөөллийг хангахаар 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсан байна.

2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оны эхэнд Засгийн газрын ХААУХШМ-ийн системд оруулан Өглөөний сонин, орон нутгийн “Заман” сонинд нийтэлж, аймгийн “Tender.bo.mn”, “bayan-ulgii.gov.mn”, “e-procurement.mn”, “mers.gov.mn” сайтуудаар тус тус нийтэд зарлан мэдээлсэн байна.

Худалдан авах ажиллагааны алба нь 2016 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний товч тодорхойлолт, тендерийн бичиг баримт, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер зэргийг цахим хэлбэрээр хадгалжээ. Үнэлгээний хорооноос тендер шалгаруулсан явцад хуулинд заасан хугацааг зөрчсөн, худалдан авах аргыг зөрчсөн зөрчил гараагүй байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбоотой нэг зөрчил гарчээ.

Гэвч тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбоотой “Алтанцөгц сумын Хүүхдийн цэцэрлэгийн халаалтын засвар”-ын төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооноос тендерийн бичиг баримттай холбоотой зөрчилтэй гэж үзээд хамгийн бага үнийн санал гаргасан “Лана” ХХКомпаныг гүйцэтгэгчээр шалгаруулахаас татгалзсан үнэлгээний хорооны шийдвэрийг

Сангийн яамнаас гомдлын мөрөөр хянаж үзээд уг шийдвэрийг үндэслэлгүй гэж зөвлөмж ирүүлжээ.

Үүний дагуу дээрхи ажилд тендерийн үнэлгээг дахин хийж хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Лана” ХХКомпанитай гэрээ хийхээр үнэлгээний хорооноос дүгнэлт гаргажээ. Иймд үнэлгээтэй холбоотой гаргасан дээрхи зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэв.

2.2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны журмыг зөрчсөн, өрсөлдөөнийг хязгаарласан эсэх талаар.

Худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж ажилласан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газраас тогтоосон босго үнийг баримтлан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 5, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 10 нийтдээ 15 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар, босго үнийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй 450,9 сая төгрөгийн өртөг бүхий “Асрамжийн газар барих” төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу явуулжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжихээр батлагдсан босго үнээс бага төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээний хүрээнд гэрээ байгуулах замаар нийтдээ 62,8 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан ба 2 цэргийн ангид хэрэгжсэн 46,6 сая төгрөгийн өртөг бүхий 2 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагч болох аймгийн ЗДТГазрын даргаас төсөл хэрэгжиж байгаа 2 цэргийн ангитай шууд гэрээ байгуулах журмаар хэрэгжүүлсэн байна.

2.3. Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж тайлагнасан эсэх талаар.

Худалдан авах ажиллагааг хугацаандаа зохион байгуулж, ТАХ-г хугацаандаа хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Худалдан авах ажиллагааны алба нь бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр 2016 оны худалдан авах ажиллагааг 2016 оны 2 дугаар сараас эхлэн төлөвлөгөөний дагуу 7 дугаар сард багтаан зохион байгуулахаар төлөвлөж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 5 ажлын, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 9 ажлын нийтдээ 14 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлсэн байна.

Эрх шилжүүлсэний дагуу аймгийн Татварын хэлтсээс зохион байгуулсан худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 2016 оны 5 дугаар сард зохион байгуулжээ.

Тус аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь 2016 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний товч тодорхойлолт, тендерийн бичиг баримт, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер зэргийг цахим болон цаасан хэлбэрээр төсөл арга хэмжээ бүрээр архивын нэгж болгон хадгалсан байна.

Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг улирал бүр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг мэдээлэх, тайлагнах журмын дагуу маягт 1, 2-оор гаргаж аймгийн Засаг даргаар батлуулан улирал бүр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байсан байна.

2.4. Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, үр ашиггүй зарцуулсан эсэх талаар.

Худалдан авах ажиллагааны явцад төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон тендерт шалгарсан өртгийн зөрүүгээр улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 5 төсөл арга хэмжээнд 38,8 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 9 төсөл арга хэмжээнд 21,2 сая төгрөгийн нийтдээ 60,0 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан тооцоо гарч байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын дансны хэмнэлт нь Хөрөнгө оруулалтын нэгдсэн дансны үлдэгдлээр байх ба орон нутгийн хөрөнгө оруулалтын тендерийн хэмнэлт нь аймгийн Төрийн сан дахь Орон нутгийн хөрөнгө оруулалтын харилцах дансны үлдэгдлийн дүнд орж 2016 оны эцэст 41,8 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

2.5. Худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэхдээ хугацаа алдах, бэлтгэл ажил хангагдсан ТАХ-д гүйцэтгэгч сонгон шалгаруулсан эсэх талаар.

Худалдан авах ажиллагааны албанд эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэгч сонгон шалгаруулсан хугацааг авч үзэхэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг 2016 оны 2 дугаар сарын 19-нөөс эхлэн 7 дугаар сарын 06-ны хооронд явуулсан ба тендерт шалгарсан гүйцэтгэгчидтэй тендерийн хүчинтэй хугацаанд гэрээ байгуулагдсан байна.

2.6. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТАХ-ний зориулалтыг өөрчилсөн эсэх талаар.

Худалдан авах ажиллагааны явцад төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн тохиолдол гараагүй байна.

Бүлэг 3

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих сургуулийн барилгын ажлын хэрэгжилт удаашралтай байна

3. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний гэрээний хэрэгжилт, санхүүжилт үр нөлөөтэй, үр ашигтай явагдсан эсэх талаар.

3.1. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлүүд тодорхойгүй, оновчтой бус хугацаа хэтэрсэн эсэх талаар.

Төсөл арга хэмжээний гэрээ тус бүр дээр Гэрээний ерөнхий нөхцөл, Захиалагчийн эрх үүрэг, Гүйцэтгэгчийн эрх үүрэг, Захиалагч, гүйцэтгэгчийн харилцан хүлээх үүрэг, Гэрээний нэмэлт нөхцөл, Гэрээний тусгай нөхцөлүүдийг тодорхой зааж өгсөн байна.

Захиалагч гүйцэтгэгч нарын хооронд гэрээ хийгдсэн ба гэрээний хэрэгжилтийг авч үзвэл 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 6 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25 төсөл арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжиж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын 2-р бүрэн дунд сургуулийн хичээлийн байр”, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Асрамжийн газрын байр” барих төсөл арга хэмжээнүүдийн 2016 оны гэрээнд заасан ажлууд хийгдэж, дараа онд шилжсэн байна.

2016 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын 2-р бүрэн дунд сургуулийн хичээлийн байр барих”, “Баян-Өлгий аймгийн ЗДТГазарт тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлуудын гэрээний хугацаанд өөрчлөлт орж, нэмэлт гэрээ байгуулагдсан байна.

“Баян-Өлгий аймгийн ЗДТГазарт тоног төхөөрөмж нийлүүлэх” ажил БӨА-021/2016 тоот гэрээнд өөрчлөлт оруулсан нэмэлт гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэн ба “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын 2-р бүрэн дунд сургуулийн хичээлийн байр барих” ажлыг №БӨА-ЗДТГ-НТШ 2013/264-01/2016 тоот нэмэлт гэрээний дагуу ажил дуусах хугацааг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэж өөрчлөлт оруулсан байна.

3.2. Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, бүрэн ашигласан эсэх талаар.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

а.2016 онд БСШУСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь харилцах данснаас эрх шилжсэний дагуу 841.8 сая төгрөгийн санхүүжилтийг дараах төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид ажлын гүйцэтгэлээр зарцуулжээ.

Үүнд: Он дамжин хэрэгжиж байгаа Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн барилгын санхүүжилтэнд гүйцэтгэгч “Агайын” ХХКомпанид 700.0 сая төгрөгийн, Улаанхус сумын хүүхдийн цэцэрлэгийн байрны засварын ажилд зориулан 43.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч “Лана” ХХКомпанид, Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн байрны засварын ажилд зориулан 48,5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч “Заулим-Алтай” ХХКомпанид, Өлгий сумын Хүүхдийн цэцэрлэгийн байрны өргөтгөлийн ажлын санхүүжилтэнд 49,8 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч “Мунара констракшн” ХХКомпанид тус тус шилжүүлсэн байна.

б. ЭМСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас 2016 онд шинээр хэрэгжсэн Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засварын ажлын гүйцэтгэгч “Нур-едил” ХХКомпанид 209,4 сая төгрөгийн, он дамжин хэрэгжсэн “Нийтийн эрүүл мэндийн зориулалттай гүйлтийн талбай бүхий цогцолбор барилгын ажил”-ын үлдэгдэл санхүүжилтэнд “Монстрой-Эра” ХХКомпанид 58,3 сая төгрөгийн нийтдээ 267,7 сая төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын арга хэмжээнд ажлын гүйцэтгэлийн дагуу зарцуулсан байна.

в. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрх шилжүүлсэний дагуу “Аймгийн ЗДТГазарт тоног төхөөрөмж нийлүүлэх” төсөл арга хэмжээний гүйцэтгэгч “Ньюсоник” ХХКомпанид тоног төхөөрөмжөө нийлүүлсэний дараа 49,3 сая төгрөгийн санхүүжилт олгогдож 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэний дагуу нийтдээ **1158,8** сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч компаниудад ажлын гүйцэтгэлээр олгожээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн талаар:

Аймгийн ИТХ-ын 2016 оны хуралдааны 71 тоот тогтоолоор 2015 оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс санхүүжүүлэн 2016 онд хэрэгжүүлэхээр 854,7 сая төгрөгийн өртөг бүхий 26 төсөл арга хэмжээг, ирэх онд хэрэгжих ТАХ-ний зураг төсвийн зардал, тусламжийн хөрөнгийн тээврийн зардал, гадаадын тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээний орон нутгийн оролцоо зэрэг зардлуудад 151,4 сая төгрөг нийтдээ 1006,1 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын чиглэлээр зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь 020051300 тоот данснаас 2016 оны 4 дүгээр сарын 21-ээс 2016 оны 12 дугаар сарын 26-ны хооронд ажлын гүйцэтгэлээр 827,6 сая төгрөгийг хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтээр олгож, 137,1 сая төгрөгийг батлагдсан төсвийн дагуу бусад зардалд зарцуулж, оны эцэст дансны үлдэгдэл болох 41,8 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Ажлын гэрээний дагуу урьдчилгаа, явцын, үлдэгдэл санхүүжилтийг ажил гүйцэтгэгчээс гаргасан эрх бүхий албан тушаалтнуудаар хянуулан батлуулсан ажлын гүйцэтгэлийн баримтыг үндэслэн гэрээнд заасан харилцах дансанд нь шилжүүлэх замаар санхүүжилтийг олгож ирсэн байна.

Тухайлбал: Аймгийн ХДТ-ын гадна талын засварын ажлыг гүйцэтгэгч “Ёлт констракшин” ХХК-д 53,0 сая төгрөгийг, Улаанхус сумын Хөх хөтөл багийн сургуулийн спорт заалны засварын ажлыг гүйцэтгэгч “Монстрой-Эра” ХХКомпанид 43,8 сая төгрөгийг, Дэлүүн сумын Бүрэн дунд сургуулийн дээврийн засварын ажлыг гүйцэтгэгч “Мунара-констракшн” ХХКомпанид 62,0 сая төгрөгийг, Асрамжийн газар барих ажлын гүйцэтгэгч “Ганбарс” ХХКомпанид 170,0 сая төгрөгийг, Аймгийн

Нэгдсэн эмнэлгийн халаалтын шугамын засварын ажлын гүйцэтгэгч “Алтайн шар говь” ХХКомпанид 18,8 сая төгрөгийг, Алтанцөгц Хүүхдийн цэцэрлэгийн халаалтын шугамын засварыг гүйцэтгэгч “Лана” ХХКомпанид 19,3 сая төгрөгийг, Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид Соёлын төвийн засварын ажилд 24,6 сая төгрөгийг, Хилийн цэргийн 0165 дугаар ангид Даянгийн заставын уулзалтын байр барих ажилд 21,6 сая төгрөгийг, ГИХШАлбаны байрны засварын ажлыг гүйцэтгэгч “Нурбах” ХХКомпанид 8,4 сая төгрөгийг, Боловсрол соёлын газрын конторын засварын ажлыг гүйцэтгэгч “Наз-алем” ХХКомпанид 9,8 сая төгрөгийг, Боловсрол соёлын газрын машины их засварын ажлыг гүйцэтгэгч “Хангайжин” ХХКомпанид 7,8 сая төгрөгийг, Сагсай сумын Даян бага сургуулийн дотуур байрны засварын ажлын гүйцэтгэгч “Балхарагай” ХХКомпанид 4,0 сая төгрөгийг, Төв талбайн шинэчлэлийн ажлыг гүйцэтгэгч “Бодьбуян” ХХКомпанид 67,0 сая төгрөгийг, Төв талбайн шинэчлэлийн ажлын туслан гүйцэтгэгч “Акбоар” ХХКомпанид материалын үнийн зөрүүд “Төв талбайн шинэчлэл”-ийн ажлын зураг төсөвт экспертиз хийлгэсэн дүгнэлтийн дагуу 170,0 сая төгрөгийг, Хүүхдийн паркийн худаг, бие засах газар барих ажлыг гүйцэтгэгч “Монстрой эра” ХХКомпанид 3,0 сая төгрөгийг нийтдээ **683,1** сая төгрөгийг 2016 онд хийж гүйцэтгэсэн барилга угсралтын болон засварын ажлын санхүүжилтээр тус тус олгосон байна.

Цагдаагийн газарт эргүүлийн машин нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Асгат кент” ХХКомпанид 10,0 сая төгрөгийг, ШШГАлбанд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Бек толхын” ХХКомпанид 4,7 сая төгрөгийг, Прокурорын газарт тавилга эд хогшил нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Ернур-Аз” ХХКомпанид 6,0 сая төгрөгийг, Татварын хэлтэст тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Кен дала” ХХКомпанид 18,0 сая төгрөгийг, Сумдын Төрийн санд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Би Си Ти” ХХКомпанид 18,4 сая төгрөгийг, Улаанхус сумын Ойгор багийн Засаг даргад эд хогшил нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Үш хара” ХХкомпанид 5,0 сая төгрөгийг, Нэгдсэн эмнэлэгт цахилгааны генератор нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Ахжол” ХХКомпанид 6,0 сая төгрөгийг, Бугат, Булган сумд автомашин нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Өлгий-Буянт” ХХКомпанид 49,9 сая төгрөгийг, Цэнгэл сумын ЗДТГазарт авто машин нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Молкен” ХХКомпанид 24,9 сая төгрөгийг, Гаалийн газарт эд хогшил нийлүүлэх ажлын гүйцэтгэгч “Аулым” ХХКомпанид 1,6 сая төгрөгийг нийтдээ **144,5** сая төгрөгийг гэрээний дагуу машин, тоног төхөөрөмж, эд хогшил бэлтгэхэд зориулан санхүүжүүлсэн байна.

3.3. ТАХ-ний ажлын гүйцэтгэл дутуу болон хуурамч гүйцэтгэлд санхүүжилт олгосон, талуудын хяналт хангалтгүйгээс зураг төсөвт өөрчлөлт орсон, үргүй зардал гаргасан эсэх талаар.

Төсөлт ажил тус бүр дээр гүйцэтгэгч компаниуд үе шатны ажлын хуваарийг ажлын төрөл, өртөг, хугацаагаар нь гарган Барилгын захиалагчийн алба болон болон ГХБХБГ-ын хяналтын инженерээр хянуулан батлуулдаг байна.

Төрийн сангаас гүйцэтгэгч байгууллагуудад олгох санхүүжилтийг ажлын үе шатаар нь гаргасан гүйцэтгэлийн дагуу олгож ирсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр ХЦ-ийн 0165 дугаар анги гэрээгээр гүйцэтгэсэн “Даянгийн заставын уулзалтын байр барих” төсөл арга хэмжээний урьдчилгаа болон явцын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр нь олгож байсан ба үлдэгдэл санхүүжилт болох 9,7 сая төгрөгийг “Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт” гараагүй байхад гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу бүрэн олгож, “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.7-д заасныг зөрчжээ. Иймд төсвийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээг

холбогдох эрх бүхий шийдвэр гарсаны дараа үлдэгдэл санхүүжилтийг олгож байхыг зөвлөмж болгов.

3.4. ТАХ-ний санхүүжих дүн дутуу батлагдсанаас, бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлээгүйгээс арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшилсон эсэх талаар.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих зарим ТАХ-ний хэрэгжилт санхүүжилттэй холбоотойгоор удаашралтай байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 оноос хэрэгжихээр гэрээ хийгдсэн “Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 2-р бүрэн дунд сургуулийн хичээлийн байр барих” ажлыг анхны гэрээгээр 2015 оны 9 дүгээр сарын 1-нд дуусган ашиглалтанд оруулах ёстой байсан бөгөөд 2013 онд царцаасан барилгын жагсаалтад орж санхүүжилт хийгдээгүй байна.

2014 оны төсвийн хуулиар 2300,0 сая төгрөгийн төсөв батлагдан 1100,9 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, батлагдсан төсвөөс 1199,1 сая төгрөгийн санхүүжилт дутуу хийгдсэн байна.

2015 оны төсвийн хуульд батлагдсаны дагуу 924,0 сая төгрөгийн санхүүжилт олгогдож 2014, 2015 оны байдлаар нийтдээ 2025,7 сая төгрөгийн санхүүжилт олгогдон мөн хэмжээний ажил хийгджээ.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийг үндэслэн “Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 2-р бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан № БӨА-ЗДТГ-НТШ 2013/264-01/2014 тоот гэрээ”-ний нийт төсөвт өртөг болон гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт орсон байна.

Үүний дагуу №БӨА-ЗДТГ-НТШ 2013/264-01/2015 тоот нэмэлт гэрээ хийгдэж сургуулийн нийт төсөвт өртөгийг 3770,7 сая төгрөгөөр, ажил дуусах хугацааг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр гэж өөрчлөлт оруулсан байна.

Нэмэлт гэрээний дагуу үлдэгдэл санхүүжилт болох 1745,0 сая төгрөгийн хөрөнгө 2016 оны төсөвт батлагдах ёстой боловч 2016 оны төсвийн хуулиар 700.0 сая төгрөгийн төсөв батлагдаж мөн хэмжээний ажил хийгджээ.

Эдгээр байдлаас үзэхэд сургуулийн барилгын төсөвт өртөг бүрэн хэмжээгээр батлагдахгүй, хэсэгчилэн төсөвлөгдөж ирсэнээс шалтгаалан тухайн оны төсөвт тусгагдсан хэмжээний ажил хийгдэж байгаа нь барилгын ажил удаашрахад хүргэсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан дээрхи гэрээнд дахин нэмэлт өөрчлөлт оруулан 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдөр №БӨА-ЗДТГ-НТШ 2013/264-01/2016 тоот гэрээ байгуулан уг гэрээний дагуу ажил дуусах хугацааг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэж өөрчлөлт оруулсан байна.

3.5. ТАХ-ний хэрэгжилтэд тавих талуудын хяналт хангалтгүй байх, захиалагч гэрээ дүгнэж хэрэгжилтийг хангуулсан эсэх талаар.

Эрх шилжсэн ажлуудын захиалагч нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2.2-т зааснаар

Аймгийн ЗДТГазрын дарга бөгөөд захиалагчийг төлөөлж барилга угсралтын ажилд ГХБХБГазар, Барилга захиалагчийн алба хяналт тавьсан байна.

Сангийн Сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.1-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч нь захиалагчийг төлөөлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтнуудыг томилж, шийдвэрээ Сангийн яамандаа хүргүүлсэний дагуу санхүүжилт олгох бүрдээ гүйцэтгэгчийн гаргасан үе шатны ажлын гүйцэтгэлийг захиалагчийг төлөөлж шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн хувьд ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, ГХБХБГазрын дарга, хяналтын инженер нар хянаж гарын үсэг зурсаны дараа ажлын гүйцэтгэлийг баталж захиалагчийн зүгээс тавих хяналтыг ажлын үе шатаар нь тавьж ажилласан байна.

Их засварын ажил болон бага хэмжээний төсөл арга хэмжээний ажлуудад захиалагчийг төлөөлж үе шатны ажлын гүйцэтгэлд ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, Барилга захиалагчийн алба хяналт тавьж тус албаны дарга, инженер нар хянасны үндсэн дээр ажлын гүйцэтгэлийг баталж, хийгдсэн ажлуудыг дээрхи журмын 4.2-т заасны дагуу барилга, байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын, шууд хяналтыг тавьж илэрсэн зөрчил дутагдлуудыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

3.6. Хэрэгжиж дууссан ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан эсэх талаар.

2016 онд нийтдээ 1119,0 сая төгрөгийн өртөг бүхий 31 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, ашиглалтанд хүлээж авсан бөгөөд үүнээс 925,2 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ нь барилга угсралтын ба барилга засварын ажил, үлдсэн нь 193,8 сая төгрөгийн өртөг бүхий 12 төсөл арга хэмжээ нь авто машин болон тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх ажил байна.

Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн техник, тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээж авахад захиалагчаас байгуулсан “Техник тоног төхөөрөмж ашиглалтанд хүлээж авах комиссын акт”-ын дагуу нийтдээ 193,8 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авчээ.

2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 903,6 сая төгрөгийн өртөг бүхий барилга угсралтын ба барилга засварын ажлыг “Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт”-ын дагуу ашиглалтанд хүлээж авсан ба орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн “Даянгийн заставын уулзалтын байр барих” төсөлд “Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт” гараагүй боловч 21,6 сая төгрөгийн санхүүжилтээ бүрэн авч, ашиглалтанд оруулсан байна.

3.7. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний үр ашиг хангалттай, чанарын болон ашиглалтын шаардлага хангасан эсэх талаар.

Ашиглагч байгууллагыг төлөөлж, захиалагч байгууллагууд гэрээ хийж байгаа ба гэрээндээ ашиглагч байгууллагын зүгээс тавих хяналтыг тодорхой тусгаагүй байна. Харин ашиглалтанд хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд ашиглагч байгууллагын төлөөлөл зайлшгүй орж актанд гарын үсэг зурж ирсэн байна.

2016 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтанд өгсөн төсөл арга хэмжээнүүдээс ашиглагч байгууллагуудын зүгээс захиалагч байгууллагад төслийн хэрэгжилт, ажлын чанартай холбоотой ямар нэгэн гомдол ирээгүй гэсэн тайлбарыг Барилгын захиалагчийн албанаас өгч байна.

Аудитын явцад Өлгий, Алтанцөгц, Баяннуур, Дэлүүн, Толбо, Ногооннуур, Цагааннуур, Сагсай, Улаанхус зэрэг сумдад Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг болон эдгээр сумдын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд 2016 онд БСШУ-ны Яамнаас нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, ашиглалтын байдлыг шалгаж үзлээ.

Орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдээс Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэгийн байрны их засварын ажил, Ногооннуур сумын БДС-ийн хичээлийн байрны хаалга, цонх шинэчлэх ажил, Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн байрны өргөтгөл шинэчлэлийн ажил, Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засварын ажил, Нийтийн Эрүүл мэндийн зориулалттай гүйлтийн талбай бүхий цогцолбор барих зэрэг төсөл, арга хэмжээнүүд хугацаандаа хэрэгжиж ашиглалтанд хүлээн авч, байгууллага иргэд хөрөнгө оруулалтын ажлын үр ашгийг зохих хэмжээгээр хүртэж байна.



Нийтийн Эрүүл мэндийн зориулалттай цогцолборын хувцас солих байр




Нийтийн Эрүүл мэндийн зориулалттай цогцолборын хөлбөмбөгийн болон гүйлтийн талбай



Мөсөн гулгуурын талбай



Сагсан бөмбөгийн талбай



Өлгий сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн өргөтгөл

Өлгий сумын 2-р бүрэн дунд сургуулийн хичээлийн байрны дээвэр, барилгын гадна дотор талын заслын ажил зэрэг ажлууд хийгдэж **72,3** хувийн гүйцэтгэлтэйгээр дараа онд шилжсэн ба одоогийн байдлаар ажил эхлэх бэлтгэл ажлууд хийгдэж байгаа юм байна.



Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 2-р БДС-ийн барилгын ажлын гаднах байдал



Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 2-р БДС-ийн барилгын дээвэр болон шалны ажил

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын даргын эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар Аймгийн ЗДТГазарт нийлүүлэгдсэн компьютер тоног, төхөөрөмжийг комиссын актаар хүлээж авсан байна.



Аймгийн ЗДТГазарт нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд

2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Аймгийн ХДТ-ын гадна талын засвар, Улаанхус сумын Хөх хөтөл багийн сургуулийн спорт заалны засвар, Дэлүүн сумын БДС-ийн дээврийн засвар, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн халаалтын шугамын засвар, Алтанцөгц Хүүхдийн цэцэрлэгийн халаалтын шугамын засвар, ГИХШАлбаны байрны засвар, БСГазрын конторын засвар, Зэвсэгт хүчний 340-р ангийн Соёлын төвийн засварын ажил, ХЦ-ийн 0165-р ангид Даянгийн заставын уулзалтын байр барих, Хүүхдийн паркийн худаг, бие засах газар барих, БСГазрын машины их засвар, Сагсай сумын Даян бага сургуулийн дотуур байрны засварын ажил мөн он дамжин хэрэгжиж байгаа Төв талбайн шинэчлэлийн ажил, Төв талбайн гэрэлтүүлгийн ажил зэрэг нийтдээ **1452,6** сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга засварын болон засвар, шинэчлэлийн 14 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан ба 2016 оноос эхлэн хэрэгжиж байгаа 450,9 сая төгрөгийн өртөг бүхий Асрамжийн газрын байрны барилга угсралтын ажил нь барилгын гадна талын угсралтын ажлууд дуусаад 37,7 хувийн гүйцэтгэлтэйгээр дараа онд шилжсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг газар дээр нь явж үзэхэд дараах байдалтай байна.



Өлгий сумын төвд баригдаж байгаа Асрамжийн газрын барилгын ажил



Алтанцөгц сумын Хүүхдийн цэцэрлэгийн халаалтын засварын ажил



БСГазрын контор болон 00-ын өрөөний засварын ажил



Аймгийн ХДТеатрын гадна талын засварын ажил



Төв талбайн шинэчлэл, гэрэлтүүлэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Цагдаагийн газарт эргүүлийн машин, ШШГАлбанд тоног төхөөрөмж, Прокурорын газарт тавилга эд хогшил, Татварын хэлтэс болон Сумдын Төрийн санд тоног төхөөрөмж, Улаанхус сумын Ойгор багийн Засаг даргын конторын эд хогшил, Нэгдсэн эмнэлэгт цахилгааны генератор, Бугат, Булган, Цэнгэл сумдад авто машин, Гаалийн газарт эд хогшил нийлүүлэх зэрэг төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн машин тоног төхөөрөмжүүдийг орлогод авч ашиглаж байгаа юм байна.



Булган сумд нийлүүлэгдсэн авто машин

Харин Бугат сумын ЗДТГазарт нийлүүлэгдсэн “Toyota Land Cruizer-100 4.7i V8” маркийн 89-25 БӨТ улсын дугаартай суудлын авто машиныг 2016 оны 5 дугаар сарын 27-ны өдөр төсөл хэрэгжүүлэгч “Өлгий-Буянт” ХХКомпаниас хүлээлгэн өгсөн бөгөөд эвдэрсэн тул одоогоор ашиглагдахгүй байгаа юм байна. Баталгаат хугацаа дуусаагүй байхад эвдэрсэн гэж ашиглагч Бугат сумын ЗДТГазар нь нийлүүлэгчтэй маргаан үүсгэж, хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж байгаа юм байна.

Аудитын явцад 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэгдэж тус аймагт хуваарилагдсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэлийг бүрэн бүтэн орлогод авч ашиглаж байгаа эсэхийг шалгаж үзлээ.

а/ Эрүүл мэнд, спортын сайдын багцаас 2016 онд “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийн хүрээнд цусны салбар банкинд нийлүүлэх цусны тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу бүрэн бүтэн авсан эсэхийг шалгаж үзэхэд нийтдээ 36 төрлийн цусны лабораторын тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн байна.



Цусны салбар төвд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд

б. Хөдөлмөрийн яамнаас Хөдөлмөрийн хэлтэст 2,9 сая төгрөгийн тоног төхөөрөмж мөн Мэргэжил сургалт, үйлдвэрийн төвд 55,3 сая төгрөгийн үнэ бүхий 45 төрлийн сургалтын тоног, төхөөрөмж хуваарилагдсаныг хуваарийн дагуу бүрэн хүлээн авч орлогод бүртгэсэн байна.

в. Боловсрол Соёл Шинжлэх ухааны яамнаас хуваарилагдсан 385,4 сая төгрөгийн хөрөнгийг хуваарьт байгууллагуудад бүрэн бүтэн хүлээлгэж өгсөн эсэхийг шалгаж үзэхэд: Өлгий сумын 1, 4, 5 дугаар БДСургууль, Хүүхдийн 10-р цэцэрлэг, Алтанцөгц, Бугат, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цагааннуур, Цэнгэл сумдын БДСургуулиудад хуваарилагдсан сургалтын тоног төхөөрөмжүүд хуваарийн дагуу бүрэн олгогдсон байна.

Харин Өлгий сумын 2, 3 дугаар БДСургууль, Эрдэм цогцолбор бага сургууль, Өлгий сумын 7, 15, 16, 17, 18 дугаар Хүүхдийн цэцэрлэг, Алтай, Баяннуур, Булган БДСургуулиудад олгох нийтдээ 451 ширхэг **97,3** сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжийг БСУГазраас дахин хуваарилалт хийж, яамнаас ирүүлсэн хуваарийг зөрчсөн байна.

БСУГазар Яамнаас хуваариласан **78,6** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хэрэгцээ шаардлагыг нь харгалзан өөр сургууль, цэцэрлэгүүдэд олгож зохицуулалт хийсэн гэсэн тайлбарыг холбогдох нотлох баримтуудын хамт ирүүлсэн. Үүнийг тодруулан авч үзвэл:

1.Өлгий сумын 2-р БДСургуулийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс Дэлүүн сумын БДСургуульд 3,9 сая төгрөгийн, Толбо сумын БДСургуульд тус бүр 3,9 сая төгрөгийн, Өлгий сумын 5-р БДСургуульд тус бүр 3,9 сая төгрөгийн сурагчийн ширээ сандал, Улаанхус сумын БДСургуульд 12,2 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Улаанхус сумын Хөххөтөл дунд сургуульд 4,7 сая төгрөгийн 6 настай хүүхдийн ширээ сандал нийтдээ **28,6** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хуваарилан олгосныг тухайн сургуулиуд сургалтын ажилд хэрэглэж байгаа юм байна.

2.Өлгий сумын 3-р БДСургуулийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс **2,4** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Өлгий сумын 5-р БДСургуульд олгосон.

3.Өлгий сумын Хүүхдийн 7-р цэцэрлэгийн хуваарьт **1,2** сая төгрөгийн компьютерийг Дэлүүн сумын Хүүхдийн цэцэрлэгт олгосон.

4.Өлгий сумын Хүүхдийн 15-р цэцэрлэгийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс 0,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Булган сумын БДС-д, 1,1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Булган сумын Ёлт бага сургуульд, 1,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгт, 2,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Улаанхус сумын Хөххөтөл дунд сургуульд бүгд **5,8** сая төгрөгийн хөрөнгийг олгосон.

5.Өлгий сумын Хүүхдийн 16-р цэцэрлэгийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс 1,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Булган сумын Шүвдэр бага сургуульд, 4,6 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг Булган сумын БДСургуульд бүгд **5,9** сая төгрөгийн хөрөнгийг олгосон.

6.Өлгий сумын Хүүхдийн 17-р цэцэрлэгийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс 2,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Улаанхус сумын Хөххөтөл дунд сургуульд, 1,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Булган сумын Ёлт бага сургуульд, 0,6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Бугат сумын БДСургуульд, **1,4** сая төгрөгийн тоног

төхөөрөмжийг Ногооннуур Хүүхдийн цэцэрлэгт нийтдээ **5,4** сая төгрөгийн хөрөнгийг дээрхи 4 байгууллагад олгосон.

7.Өлгий сумын Хүүхдийн 18-р цэцэрлэгийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс **5,9** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Булган сумын БДСургуульд олгосон.

8. Алтай сумын БДС-ийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс 6,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Цагааннуур тосгоны БДС-д, 1,1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Толбо сумын БДС-д, 3,2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Сагсай сумын БДС-д нийтдээ **10,8** сая төгрөгийн хөрөнгийг олгосон.

9.Баяннуур сумын БДС-ийн хуваарьт хөрөнгөнөөс **10,8** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Толбо сумын БДС-д олгосон.

10. Эрдэм цогцолбор сургуулийн хуваарьт **0,6** сая төгрөгийн үнэ бүхий 3 номын шүүгээг Өлгий сумын 5-р БДСургуульд олгосон.

11. Булган сумын БДС-ийн хуваарьт **1,2** сая төгрөгийн үнэтэй ширээний компьютерийг Бугат сумын БДС-д олгосон байна.

Үүнээс гадна Өлгий сумын 3-р БДСургуулийн хуваарьт тоног төхөөрөмжнөөс 7,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг БСШУЯамны хөрөнгө оруулалтын газраас татаж аваагүй, Баяннуур сумын БДС-ийн хуваарьт давхар ор, хувцасны шүүгээ зэрэг 9,7 сая төгрөгийн хөрөнгийг Яамнаас тухайн үед БСГазарт сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан Х.Серикгүл нь падаанд гарын үсэг зурж хүлээн авсан боловч хуваарьт байгууллагад нь олгогдоогүй байна.

Мөн БСУГазраас Баяннуур сумын БДС-ийн захирлаар ажиллаж байсан Х.Гүлзатад хүлээлгэн өгсөн 1.2 сая төгрөгийн үнэ бүхий ширээний иж бүрэн компьютерийг байгууллагад хүлээлгэж өгөөгүй байна.

Аудитын дүнгээр тухайн байгууллагуудаас өгсөн захиалга, БСШУЯамны хуваарийг зөрчиж БСГазраас зохицуулалт хийсэн нэрээр 11 байгууллагын хуваарьт **78,6** сая төгрөгийн хөрөнгийг өөр байгууллагуудад олгосон зөрчлийг арилгаж, яамны хуваарийн дагуу буцаан олгох, мөн БСШУЯамнаас хугацаандаа татан аваагүй 7,8 сая төгрөгийн хөрөнгийг татаж авах, Х.Серикгүлийн яамнаас гарын үсэг зурж авсан гэх 9,7 сая төгрөгийн хөрөнгийг зохих эздээс нь авч хуваарьт байгууллагуудад олгох, Баяннуур сумын БДС-ийн захирал байсан Х.Гүлзатад гардуулж өгсөн 1.2 сая төгрөгийн иж бүрэн компьютерийг Баяннуур сумын БДС-д хүлээлгэн өгч, орлогод авхуулж **97,3** сая төгрөгийн зөрчлийг арилгахыг БСУГазарт албан шаардлагаар үүрэг болгов.

Аудитын дүнгээр нийтдээ **513.2** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч, үүнээс **97,3** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгч, бусад зөрчил дутагдлыг цаашид анхаарч ажиллах талаар аймгийн ИТХурлын дарга, Засаг даргад зөвлөмж хүргүүллээ.Мөн БСУГазрын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах санал хүргүүллээ.

Өнгөрсөн оны гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Өнгөрсөн оны гүйцэтгэлийн аудитаар 1 албан шаардлага, 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг давтан шалгаж үзэхэд зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх талаар тодорхой төлөвлөгөө гаргаж, ажил зохион

байгуулан албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тухайн онд багтаан аймгийн Аудитын газарт ирүүлсэн.

ЦШСГазарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 1578,1 сая төгрөгийн өртөг бүхий Өлгий сумын 6 квт-ын цахилгаан хуваарилах байгууламжийг орлогод авагдаагүй байсныг албан шаардлагын дагуу 2016 оны эхний хагас жилийн тайлангаар орлогод авч зөрчлийг арилгасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн хөгжлийн бодлогод уялдуулах, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар автомашин худалдан авах хөрөнгийг төлөвлөж оруулахдаа машин техникийн марк, техникийн үзүүлэлт зэргийг тодорхой зааж, үнийн саналыг үндэслэлтэй тогтоох талаар зөвлөмж өгөгдсөн байна. 2016 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөж батлахад зөвлөмжид дурьдсан зөрчлүүд давтагдаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, гүйцэтгэлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг өгч байна.

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2016 оны төлөвлөгөөнд орон нутагт чухал шаардлагатай тулгамдсан төсөл арга хэмжээнүүд орсон байна.
2. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр явуулсан нь худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нөхцөл боломжийг бүрдүүлжээ.
3. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.
4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.
5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 6 дугаар зүйлийн 6.6.6-д заасан шаардлагыг мөрдөөгүй байна.
6. 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэж, БСШУЯ-наас олгосон сургалтын тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэлүүд нь зарим сургууль, цэцэрлэгүүдэд хуваарийн дагуу олгогдоогүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан танаа:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг мөрдөж ажиллах;

Аймгийн Засаг дарга А.Гылымхан танаа:

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-г үндэслэн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг зөвхөн тухайн шатны чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах;
2. Үнэлгээний хорооны үйл ажиллагаанд шударга байдлыг хангаж, хууль журмыг мөрдөж ажиллахад анхаарах;
3. Хөрөнгө оруулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ыг мөрдөж ажиллах;
4. Хэрэгжилт удаашралтай байгаа “Өлгий сумын 2-р Бүрэн дунд сургуулийн хичээлийн байр барих” төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжиж байгаа бүх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт нь арилгуулах арга хэмжээ авч ажиллах;

Холбогдох байгууллагын санал



АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд хийгдсэн гүйцэтгэлийн аудит нь зохих хууль, журам, зааврын дагуу хийгдсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн 3 төрлийн зөвлөмжийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэж, тодорхой төлөвлөгөөтэй ажил зохион байгуулж, ажлын үр дүнг нийтэд сурталчлах арга хэмжээ авч ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЕРБОЛ



ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х. ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ
АУДИТОР

К.РИЗА
Ж.НАЗГҮЛ

